БАТЛАВ:
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ш.БАЯНМӨНХ

2019-2020 ОНЫ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХАМТЫН ГЭРЭЭГ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Гэрээний заалт	Хамтын гэрээний заалт	Хариуцах нэгж, албан тушаалтан	Сар /Хэрэгжүүлэх хугацаа, биелэлт нэгтгэн хүргүүлэх/											
				I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
1.	2.	3.	4.	5											
1.	Нийтлэг үндэслэл	Энэхүү гэрээ хүчин төгөлдөр болмогц өмнө байгуулагдсан бүх хөдөлмөрийн гэрээний заалтуудад энэ гэрээний дагуу нэмэлт өөрчлөлт оруулах буюу шинэчлэн байгуулна.	Хуулийн мэргэжилтэн												
2.	Нийтлэг үндэслэл	Энэ гэрээний заалтуудаас илүү нөхцлөөр байгуулагдсан хөдөлмөрийн гэрээний заалтууд хэвээр мөрдөгдөнө.	ХНМ												
3.	2.1	Ажил олгогч нь үйлдвэрлэлийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах нөхцөл бүрдүүлнэ.	Тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер												
4.	2.2	Компанийн бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орох, хувьчлах, нэгж татан буугдсаны улмаас ажилтнуудыг бөөнөөр халах тохиолдолд ажилтнуудын төлөөлөлд 45 хоногийн өмнө мэдэгдэж, ажилтны хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хангах, нийгмийн хамгааллын талаар тусгай хэлэлцээр хийж шаардлагатай гэж үзвэл орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн албанд бичгээр мэдэгдэнэ.	ХНМ, Хуулийн мэргэжилтэн												

5.	2.3	Компанийн Гүйцэтгэх захирал нь “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 20 дугаар зүйлийг үндэслэн бүтэц, орон тооны дээд хязгаарыг Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулж, ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулах ба хамтын гэрээнд заасан нөхцөлөөр тохирч болно.	ХНМ	
6.	2.4	Компанийн Гүйцэтгэх захирал нь “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийг үндэслэн ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилд авч албан тушаалын ба тарифт цалинг олгох, мөн гэрээг цуцалж ажлаас чөлөөлнө.	ХНМ	
7.	2.5	Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын 2010 оны 16 дугаар тушаалаар батлагдсан Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолтын дагуу албан тушаалын цалин ба тарифт цалин, хөдөлмөрийн норм нормативыг боловсруулж Гүйцэтгэх захирлын тушаалаар баталж мөрдөнө.	Эдийн засагч	
8.	2.6	Нийт албан тушаалын 4 хувийн орон тоонд өмнө нь тус станцад ажиллаж байгаад үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогод өртөж хөдөлмөрийн чадвараа түр алдсан ажилтнуудыг авч ажиллуулна.	ХНМ	
9.	2.7	Үйлдвэрлэлийн удирдах албан тушаалд эрчим хүчний мэргэжлийн бус, ажлын дадлага туршлагагүй хүнийг ажиллуулахыг хориглоно.	Гүйцэтгэх захирал	
10.	2.8	Ажил олгогч эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүрийн 5-ны дотор шилжүүлэх асуудлыг хариуцна. Үүнд ажилтны төлөөлөл хяналт тавина. Шимтгэлийг шилжүүлээгүй үед нь ажилтан эмнэлэгт хэвтэж өөрөө төлбөрөө төлсөн хохирлыг ажил олгогч хариуцна.	Цалингийн нягтлан бодогч	

11.	2.9	Үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг хангахын тулд зайлшгүй тохиолдолд өндөржүүлсэн бэлэн байдлын дэглэм тогтоон ажиллуулж болно.	Гүйцэтгэх захирал	
12.	2.10	Ажилтныг ажилд авах, ажлаас чөлөөлөх, халах болон сахилгын шийтгэл ногдуулахдаа хөдөлмөрийн хууль болон бусад хууль, холбогдох дүрэм, журам, компанийн хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээгээр зохицуулна.	Хуулийн мэргэжилтэн, ХНМ	
13.	3.1	Компанийн захиргаа нь ажилтнуудын цалин хөлсийг 2019 онд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, Эрчим хүчний салбарын цалингийн сүлжилийн итгэлцүүрийн дагуу өсгөн нэмэгдүүлнэ. 2020 онд үйлдвэрийн үр ашиг, дулааны үнийн тарифын өсөлттэй уялдуулан өсгөн нэмэгдүүлэх асуудлыг хамтын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэнэ.	Гүйцэтгэх захирал	

14.	3.2	**Нэмэгдэл хөлс** 3.2.1 Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил, албан тушаал хавсран ажиллавал үндсэн цалингийн 40 хүртэл хувиар нэмэгдэл хөлс олгоно. /ажил олгогч, ажилтан харилцан тохиролцсон байна/.	ХНМ, Цалингийн нягтлан бодогч
		3.2.2 Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ эзгүй байгаа удирдах ажилтныхаа ажил үүргийг орлон гүйцэтгэвэл компанийн захиргаа тухайн ажилтанд орлон ажиллах хугацаанд нь үндсэн цалингийн 40 хүртэл хувиар нэмэгдэл хөлс олгож болно./ээлжийн амралттайгаас бусад тохиолдолд/	ХНМ, Цалингийн нягтлан бодогч
		3.2.3 Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ ажлын байрныхаа тодорхойлолтонд заагаагүй нэмэгдэл ажил үүргийг гүйцэтгэвэл компанийн захиргаа ажилтантай тохиролцон 30 хүртэл хувиар нэмэгдэл хөлс олгоно.	ХНМ, Цалингийн нягтлан бодогч
		3.2.4 Ээлжийн графикаар шөнө ажилласан ажилтанд албан тушаалын болон тарифт цалингийн 50 хувиар тооцож үндсэн цалин дээр нь нэмэгдэл хөлс олгоно.	ХНМ, Цалингийн нягтлан бодогч
		3.2.5 Ажлын өдрийн тогтоосон цагийг хэтрүүлэн илүү цагаар болон 7 хоногийн амралтын өдөр ажилтныг ажиллуулж нөхөн амруулаагүй бол түүнд цагийн үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлж олгоно.Нийтээр амрах баяр ёслолын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол үндсэн болон тарифт цалинг 2 дахин нэмэгдүүлж олгоно.	ХНМ, Цалингийн нягтлан бодогч
		3.2.6 Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэдэг буюу бусдаас илүү дэвшилтэт арга барилаар ажиллаж мэргэшлийн өндөр ур чадвар гаргаж байгаа ажилтанд ур чадварын нэмэгдэл олгох журмыг Гүйцэтгэх захирлын тушаалаар батлан мөрдөнө.	ХНМ, Эдийн засагч
			ХНМ

		Нэмэгдэл: 3.3.1 Эрчим хүчний салбарт удаан жил ажилласны нэмэгдлийг дараах хүснэгтийн дагуу олгоно. Үүнд: **Үүнд** **Ажилласан жил** / **Хэвийн бус нөхцөл** / **хэвийн нөхцөл** 1 / 2-4 жил хүртэл / 15% / 10% 2 / 4-7 жил хүртэ / 25% / 20% 3 / 7-10 жил хүртэл / 30% / 25% 4 / 10-15 жил хүртэл / 35% / 30% 5 / 15 ба түүнээс дээш жил / 40% / 35%	ХНМ, Цалингийн нягтлан бодогч
15.	3.3	3.3.2 Удирдах дээд байгууллагын шийдвэрээр томилогдсон ажилтны мэргэжил, ур чадвар, дадлага туршлагыг нь харгалзан ажилд авсан ажилтан, хөдөлмөрийн чадвар алдсан ажилтан ажилдаа эргэн орсон тохиолдолд удаан жилийн нэмэгдлийг тооцон олгоно.	ХНМ
		3.3.3 Эрчим хүчний зөвлөх инженерт албан тушаалын 20%-тай, мэргэшсэн инженерт үндсэн цалингийн 15%-тай тэнцэх хэмжээний, мэргэшсэн нягтлан бодогчид Засгийн газрын болон бусад тогтоолын дагуу үндсэн цалингаас нь 15 хувиар тооцон нэмэгдлийг сар бүр олгоно.	ХНМ
		3.3.4 Тус компанид ажиллаж байгаа ажилтан ажлын шаардлагаар ажлын байр сольж дагалдан ажиллавал өмнө ажиллаж байсан албан тушаалын ба мэргэжлийн зэргийн тарифт цалин, удаан жилийн нэмэгдлийг олгоно.	ХНМ

16.	3.4	Шагнал урамшуулал 3.4.1 Сарын үйлдвэрлэлийн үр дүнгийн урамшууллыг ажилтны үндсэн цалингийн 50 хүртэл хувиар Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан журмын дагуу олгоно. 3.4.2 Жилийн үр дүнгийн урамшууллыг ажилтны 5 хүртэлх сарын албан тушаалын үндсэн цалингийн хэмжээгээр тооцон олгоно. 3.4.3 Ажилтан идэвх зүтгэлтэй ажиллаж алдагдсан хөрөнгийг олж илрүүлсэн бол компанийн болон гэрээт байгууллагын ажилтан иргэдэд мөнгөн урамшуулал олгож болно. 3.4.4 Их болон урсгал засварын ажил, өвлийн их ачааллыг давахад хамт олноо манлайлан идэвх зүтгэлтэй ажилласан 10-аас доошгүй ажилтнуудыг дотоодын тойрон аялалын эрхийн бичгээр, Үйлдвэрчний эвлэлийн хорооны гишүүнийхээ эрх үүргийг биелүүлэн ажилласан 4 гишүүнийг гадаадын тойрон аялах эрхийн бичгээр шагнана.	ХНМ, Цалингийн нягтлан бодогч ХНМ, Цалингийн нягтлан бодогч Материалын нягтлан бодогч ХНМ, Аж ахуй эрхэлсэн Дэд захирал, ҮЭ-ийн хорооны дарга	
17.	3.5	Ажилтны буруу биш шалтгаанаар гарсан сул зогсолтын хугацаанд ажилтныг өөр ажлаар хангах боломжгүй тохиолдолд 5 дугаар сарын 1-ний өдрөөс 9 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд сул зогсолтонд хамруулж, сул зогсолтын олговорыг уг ажилтны үндсэн цалингийн 60 хувиар тооцож олгох бөгөөд сул зогсолтын олговор нь салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур байж болохгүй.	ХНМ, Цалингийн нягтлан бодогч	
18.	3.6	Хөдөлмөрийн хөлс олгохтой холбогдсон дүрэм журам, тэдгээрт оруулсан нэмэлт өөрчлөлтийг мөрдөж эхлэхээс 10 хоногийн өмнө нийт ажилтнуудад танилцуулна.	Хуулийн мэргэжилтэн	

19.	3.7	Шинээр ажилд орж байгаа ажилтанд дагалдангийн хугацаанд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх цалин хөлс олгоно.	ХНМ, Цалингийн нягтлан бодогч												
20.	4.1	Ээлжийн бус ажилтнуудын долоо хоногийн ажлын цаг нь 40 хүртэл байна.	ХНМ												
21.	4.2	Ажилтныг илүү цагаар /Даалгаврын хуудсаар/ сард ажиллуулах дээд хэмжээ хуанлийн ажлын цагийн 30 хувиас хэтэрч болохгүй.	Цех, хэлтэс, албаны дарга, хэсэг хариуцсан ИТА												
22.	4.3	Станцад гарсан аваар устгах ажлыг зохион байгуулах, компанийн тайлан, тэнцэтгэл мэдээ гаргах, төлөвлөгөө, төсөл зохиох зэрэг цаг алдалгүй яаралтай ажил гүйцэтгэх, гэрээ хэлэлцээр байгуулахаар инженер техникийн ажилтан, ажилтнууд ажлын өдрийн тогтоосон цагийг хэтрүүлэн илүү цагаар, нийтээр амрах баярын болон долоо хоногийн амралтын өдөр ажиллуулахыг Гүйцэтгэх захирал шийдвэрлэх бөгөөд уг ажилтны илүү цагаар ажилласан цагийг нөхөн амруулаагүй бол Гүйцэтгэх захирлын тушаалаар илүү цаг ажилласны цалин хөлс олгоно.	ХНМ, Цалингийн нягтлан бодогч												

23.	4.4	Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласан хугацаанд ажилтанд түүний ажилласан хугацааг харгалзан үндсэн амралт дээр нь дор дурьдсан нэмэгдэл амралтыг олгоно. Үүнд: 4.4.1 6-10 жил ажилласан бол ажлын 6 өдөр 4.4.2 11-15 жил ажилласан бол ажлын 8 өдөр 4.4.3 16-20 жил ажилласан бол ажлын 11 өдөр 4.4.4 21-25 жил ажилласан бол ажлын 14 өдөр 4.4.5 26-31 жил ажилласан бол ажлын 17 өдөр 4.4.6 32 болон түүнээс дээш жил ажилласан бол ажлын 20 өдөр нэмж олгоно.	ХНМ, Цалингийн нягтлан бодогч	
24.	4.5	Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа эдлэж чадаагүй ажилтантай ажил олгогч тохиролцож, мөнгөн урамшууллыг Гүйцэтгэх захирлын тушаалаар дараа оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор олгоно.	ХНМ, Эдийн засагч	
25.	4.6	Захиргаа нь ажилтанд өөрийнх нь хүсэлтээр үндсэн нэгжийн удирдах ажилтны тодорхойлолтыг үндэслэн ажлын 3 хүртэлх сарын тэтгэмжгүй чөлөө олгож болох бөгөөд бусад чөлөө олголтыг “Хөдөлмөрийн дотоод журам”-аар зохицуулна.	ХНМ, Цалингийн нягтлан бодогч	

26.	4.7	Ажилтанд ажлын цагийг дор дурьдсан тохиолдлуудад богиносгоно. 4.7.1 6 сар хүртэлх насны хүүхэдтэй эхэд 2 цаг, 1 хүртэлх настай хүүхэдтэй эхэд 1 цаг, /энэ заалт ганц бие эцэгт нэгэн адил хамаарна/, жирэмсэн эхийн амралтын өмнөх нэг сард 1 цаг. 4.7.2 Ажлын цагийг нь богиносгосон ажилтанд уг хугацаанд дундаж цалин хөлсийг нь бүрэн олгоно. 4.7.3 Ажил үүргийн онцлогоос шалтгаалан завсарлах боломжгүй ажилтай ажилтныг ажил олгогч хооллох бололцоогоор хангана. 4.7.4 Ээлжийн ажилтай жирэмсэн эмэгтэй ажилтанд өөрийн хүсэлтийг харгалзан 4 сартайгаас өдрөөр ажиллуулна. /Цалин хөлс нь буурсан тохиолдолд өмнө авч байсан үндсэн цалинг олгоно/	Цех, алба, хэлтсийн дарга, хэсгийн ИТА, ХНМ, Цалингийн нягтлан бодогч,	
27.	5.1	"Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлд зааснаар" ҮО, хурц хордлого, МШӨ-ний улмаас хөдөлмөрийн чадвараа 30% хүртэл алдсан ажилтанд 5 сар, 31-50% алдсан бол 7 сар, 51-70% алдсан бол 9 сар, 71%-иас дээш алдсан бол 11 сарын цалингийн дундажтай тэнцэх хэмжээний нөхөн төлбөрийг нэг удаа олгоно".	ХАБЭА	
28.	6.1	Салбарын байгууллага болон тус компанид 10-аас дээш жил ажиллаж байгаа ажилтанд 50, 60 насны ойгоор нь 100,000 төгрөгтэй тэнцэх хэмжээний урамшуулал олгоно. Мөн өндөр настанд 60,70,80,90 насны ойгоор нь 100,000 төгрөгтэй тэнцэх хэмжээний урамшуулал олгоно. / Энэ заалт группэд гарсан хүмүүст мөн адил хамаарна./	ХНМ, Эдийн засагч	

29.	6.2	Жил бүр байгууллагын “Хөдөлмөрийн аварга”-аар 1 ажилтныг шалгаруулж хүндэт өргөмжлөл, салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4 дахин, “Тэргүүний ажилтан”-аар 3 ажилтныг шалгаруулж тус бүрийг өргөмжлөл, салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин, “Байгууллагын хүндэт дэвтэр”-т бичигдсэн ажилтныг салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин, Төрийн дээд цол, одон, медалиар шагнагдсан ажилтнуудад салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр, хөдөлмөрийн баатар цолоор шагнагдсан ажилтанд өргөмжлөл, салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1,5 дахин нэмэгдүүлсэн хэмжээний мөнгөн шагналаар тус тус шагнаж урамшуулна.	ХНМ																	
30.	6.3	Захиргаа нь байгууллагын үйл ажилагааны үр дүнг сайжруулахад бодит хувь нэмэр оруулсан ажил төрлийн холбоо бүхий аж ахуйн нэгж байгууллага, холбогдох хүмүүсийг шагнаж урамшуулж болно.	Дэд захирлууд, Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга																
31.	6.4	Ээлжийн бус ажилтанд нэг өдрийн 3000 төгрөг, ээлжийн ажилтанд гараа дутамд 5000 төгрөгийн хоолны хөнгөлөлт олгоно.	Санхүү эрхэлсэн Дэд захирал																
32.	6.5	Жилд нэг удаа нийт ажилтнууд, өндөр настан, мэргэжлээс шалтгаалах өвчин, хурц хордлогын улмаас группт байгаа хүмүүст 5 хүртэлх тонн нүүрсийг өөрийн өртгөөр нь олгоно. Уг хөнгөлөлтийг гэр бүлээрээ ажиллаж буй ажилтны нэгэнд нь олгоно.	Аж ахуй эрхэлсэн Дэд захиал																

33.	6.6	МУ-ын төрийн дээд шагнал Хөдөлмөрийн баатарт 15.000 төгрөг, МУ-ын төрийн дээд шагнал Гавьяат ажилтан, Эрчим хүчний Тэргүүний ажилтан цол тэмдэг болон тус салбарт ажиллаж байгаад бусад салбарын тэргүүний цол тэмдэгээр шагнуулсан ажилтанд сар бүр 10.000 төгрөгийн урамшууллыг Гүйцэтгэх захирлын тушаалаар жилд 1 удаа олгоно. /үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин, хурц хордлогын улмаас группт байгаа хүмүүс, ахмад настанд нэг адил хамаарах ба өөрийн хүсэлтээр болон сахилгын шийтгэлээр ажлаас халагдсан иргэдэд хамаарахгүй/.	ХНМ, Цалингийн нягтлан бодогч,																
34.	6.7	Ажилтнуудын төрсөн эцэг эх, эхнэр, нөхөр, хүүхэд нас барж уй гашуу тохиолдоход салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төгрөг, Үйлдвэрчний эвлэлийн хороо нь 200,000 төгрөгийг, ажилтан зуурдаар буюу өвчнөөр нас барсан тохиолдолд ар гэрт нь салбарын хөдөлмөрийн хөлсний хэмжээг 10 дахин хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр, Үйлдвэрчний эвлэлийн хороо нь салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлнэ. /гэр бүлээрээ болон ах дүү, хэд хэдэн хүн ажилладаг бол зөвхөн нэг хүнд олгоно/	ХНМ, Цалингийн нягтлан бодогч,																
35.	6.8	Өрх толгойлсон эцэг буюу эхэд өрхийн орлогыг нь дэмжих зорилгоор жилд нэг удаа тэтгэмж олгоно. Тэтгэмж олгохдоо 1 хүүхэдтэй эцэг буюу эхэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, 2-оос дээш хүүхэдтэй эцэг буюу эхэд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх тэтгэмжийг Улсын бүртгэлийн Ерөнхий газрын лавлагааг үндэслэн тухайн жилийн 04-05 дугаар сар, 09-10 дугаар саруудад олгоно.	ХНМ, Цалингийн нягтлан бодогч,																
36.	6.9	Тус компанийн харьяалал бүхий өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадууд, групп тогтоолгосон хүмүүс нас барвал салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төгрөгийн тэтгэмж олгоно.	ХНМ, Цалингийн нягтлан бодогч																

37.	6.10	Компаний ажилтан анх гэр бүл болоход нь салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх мөнгөн урамшуулал нэг удаа олгоно.	ХНМ, Цалингийн нягтлан бодогч,												
38.	6.11	Тус компанид ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарахаар ажлаас чөлөөлөгдсөн хүнд Эрчим хүчний салбарт ажилласан бүх жилийг тооцож ажилласан жил тутамд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төгрөгөөр нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгоно. Мөн Үйлдвэрчний эвлэлийн хорооноос гарын бэлэг өгнө.	ХНМ, Цалингийн нягтлан бодогч,												
39.	6.12	Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах үүднээс рашаан сувилалд сувилуулж амарсаны зардлыг Улсын чанартай магадлан итгэмжлэгдсэн рашаан, сувиллын илгээх бичгийг үндэслэн 10 хүртэлх хоногоор тооцож нэг өдрийн зардалд 18,000 төгрөгийг ажил олгогч, 10,000 төгрөгийг ҮЭХ-оос олгоно. Үүнд: ахмад настан, ҮО, МШӨ-ний групптэй хүмүүст нэг адил хамаарна.	ХНМ, Цалингийн нягтлан бодогч, ҮЭХороо												
40.	6.13	Байгууллагын нэрийн өмнөөс улс, хотын чанартай биеийн тамир, урлаг, уран сайхны тэмцээн уралдаанд оролцож онцгой амжилт гаргасан шилдэг ажилтныг 100,000 хүртэл төгрөгөөр шагнаж урамшуулна. Мөн тус байгууллагын ажилтны хүүхэд олон улсын спорт, урлагийн тэмцээн болон олимпиадад оролцохоор шалгарсан бол тусламж үзүүлнэ.	ХНМ, Цалингийн нягтлан бодогч, Урлаг, спорт хариуцсан зохион байгуулагч												
41.	6.14	Байгалийн гэнэтийн аюул /газар хөдлөлт, үер, гал, ус, онц аюултай цасан ба шороон шуурга/-д өртөж, хохирсон өрхөд хохирлын хэмжээг тооцон 500,000 хүртэлх төгрөгийн тусламж үзүүлнэ.	ГАБЭХИнженер ХНМ, Цалингийн нягтлан бодогч,												

42.	6.15	Үндсэн ажилтан, тэдгээрийн төрсөн эцэг, эх, эхнэр, нөхөр, хүүхэд хүнд өвчний улмаас эмчилгээний зайлшгүй шаардлагатай нөхцөл байдал үүссэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй, өрхийн нэг хүнд ноогдох орлого нь амьжиргааны баталгаажих доод түвшинд хүрэхгүй тохиолдолд өөрийн хүсэлтийг харгалзан тухайн ажилтанд жилд нэг удаа салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх мөнгөн тусламж үзүүлнэ. / гэр бүлээрээ болон ах дүү, хэд хэдэн хүн ажилладаг бол зөвхөн нэг хүнд олгоно/	ХНМ, Цалингийн нягтлан бодогч,	
43.	6.16	Нийт ажилтнуудын 0-16 насны хүүхдүүдэд шинэ жилээр гарын бэлэг өгнө. Мөн тус компанийн ажилтны хүүхэд ЕБС-ийн 12 дугаар ангийг А үнэлгээтэй төгссөн бол гэрчилгээг нь үндэслэн нэг удаа 50,000 төгрөгийн урамшуулал олгоно.	ХНМ, Цалингийн нягтлан бодогч,	
44.	6.17	Амаржсан эхчүүдэд хүүхдээ 2 нас хүртэл асрах хугацаанд сар бүр 80,000 /наян мянга/-н төгрөгийн тэтгэмж олгоно. /Ажилдаа эргэн орсон тохиолдолд тэтгэмжийг олгохгүй/.	ХНМ, Цалингийн нягтлан бодогч,	
45.	6.18	Компанийн найдвартай ажиллагааг хангах, чадварлаг боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор орон сууцгүй ажиллагсдыг орон сууцаар хангах ажлыг зохион байгуулж ажиллана.	Аж ахуй эрхэлсэн Дэд захиал	
46.	6.19	Ажилтан цэргийн алба хаах болсон тохиолдолд тухайн ажилтны орон тоог 1 жил хүртэлх хугацаагаар хадгалж, өөрийн өргөдлийг үндэслэн ажилд эргүүлэн авна.	ХНМ	
47.	6.20	Ажилтнуудад 2018 оны IV улирлаас эхлэн унааны хөнгөлөлт олгоно.	ХНМ, Цалингийн нягтлан бодогч	

48.	6.21	Компанийн бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөөр ажлын байрыг цомхотгох явцад цомхотгогдож байгаа ажилтнуудын нийгмийн баталгааг хангах зорилгоор: 6.21.1 Эрчим хүчний салбарт 5-10 жил ажилласан бол 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 6.21.2 Эрчим хүчний салбарт 11-15 жил ажилласан бол 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 6.21.3 Эрчим хүчний салбарт 16-аас дээш жил ажилласан бол 24 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тус тус олгоно.	ХНМ, Эдийн засагч, Цалингийн нягтлан бодогч	
49.	6.22	Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилтны цагийн тарифт цалин хэвийн нөхцөлд ажилладаг ажилтны тарифт цалингаас 10 хувиар өндөр тогтооно.	Эдийн засагч	
50.	7.1	Ажилтнуудын ажлын байрны сургалтыг төлөвлөгөөний үндсэн дээр зохион байгуулж гарын авлага, шаардлагатай техник хэрэгслээр хангана.	Цех, албаны дарга, ХАБЭАИ, ГАБЭХИ, Сургалт, судалгааны мэргэжилтэн	
51.	7.2	Боловсон хүчний бодлогын хүрээнд компанийн зардлаар гадаад, дотоодын их, дээд сургууль, коллежид шаардлагатай мэргэжлээр мэргэжилтэн давтан бэлтгэх зорилгоор ажилтныг гэрээгээр суралцуулж болно.	Сургалт, судалгааны мэргэжилтэн	
52.	7.3	Компани дээр зохион байгуулсан сургалтанд хичээл заасан эрдмийн зэрэг, цолгүй багш нарт нэг цагт 10,000 төгрөгийн хөлс олгоно. Эрдмийн зэрэг, цолтой бол цагийн дээрх хөлсийг доорхи хувиар өсгөж өгнө. Үүнд: Доктор 20 хувь, дэд доктор 15 хувь, дэд профессор 5 хувь, профессорт 10 хувь	Сургалт, судалгааны мэргэжилтэн	

53.	7.4	Эрчим хүчний салбарын хэмжээнд ажил мэргэжлийн уралдаан, тэмцээнд зохион байгуулалттай оролцож шинэ арга барил, ажлын туршлага мэдээлэл солилцоно.	Сургалт, судалгааны мэргэжилтэн	
54.	7.5	Ажилтны дагалдан сургалтын хугацаа нь 3 сар хүртэл байна.	Сургалт, судалгааны мэргэжилтэн	
55.	7.6	Компанийн захиалгат мэргэжлээр инженер техникийн ажилчид болон бусад ажилтан ажил олгогчтой тохиролцсоны үндсэн дээр мэргэжил дээшлүүлэх их дээд сургууль, коллежид сурахаар бол төлбөрийг гэрээний дагуу компани олгоно.	Сургалт, судалгааны мэргэжилтэн, Эдийн засагч	
56.	8.1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг сурталчлах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.	Хяналтын хэсгийн дарга, ХАБЭАИ	
57.	8.2	Компанийн ажилтнуудын ажлын байрны онцлогт тохирсон ажлын хувцасны олголтыг нэгдсэн журмаар зохион байгуулах арга хэмжээ авна.	ХАБЭАИ, Ерөнхий нягтлан бодогч, Аж ахуй эрхэлсэн Дэд захирал	
58.	8.3	Ажлын байрны хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, үйлдвэрлэлийн эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, мэргэжлээс шалтгаалах өвчин, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх, тооcжилт, чийгшлийг бууруулах төлөвлөгөө боловсруулж батлуулан мөрдөнө.	Хяналтын хэсгийн дарга, ХАБЭА	
59.	8.4	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах төлөвлөгөө боловсруулж ажиллахын зэрэгцээ олон нийтийн бусад байгууллагатай хамтарч ажиллана.	Хяналтын хэсгийн дарга, ХАБЭА	

60.	8.5	Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг нийлүүлэхээс өмнө чанарын байдалд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ажилтан хамтран үзлэг шалгалт хийх ба олгох хугацаа ашиглалтад нь хяналт тавьж ажиллана. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл хугацаандаа олгогдоогүй бол хожимдуулсан хугацааг элэгдлийн хугацаанд тооцохгүй.	Тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер, Аж ахуй эрхэлсэн Дэд захирал, Хяналтын хэсэг, ХАБЭАИ	
61.	8.6	Компанийн нийт ажлын байранд хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.	ХАБЭАИ	
62.	8.7	Хөдөлмөрийн аюултай, хортой, бусад хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилтнуудад мэргэжлийн байгууллагаас тавьсан шаардлагад нийцсэн хор саармагжуулах бүтээгдэхүүнийг олгоно.	Аж ахуй эрэлсэн Дэд захирал, ХАБЭАИ	
63.	8.8	Ажилтнуудыг жил бүр эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт хамруулна. Эмчийн дүгнэлтийг үндэслэн эрүүлжүүлэх ажлыг Үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран зохион байгуулна. Зардлыг ажил олгогч 100 хувь хариуцна.	ХНМ, ХАБЭАИ	
64.	8.9	Ажилтнуудын ажлын хувцсыг сард 4 удаа угааж цэвэрлэнэ.	ААХҮАлбаны дарга	
65.	8.10	Хөдөлмөрийн чадвар түр алдалтыг бууруулах зорилгоор ажил олгогч нийт ажилтнуудад 3 сарын турш цайны газраар аарц, чацаргана олгох бөгөөд Үйлдвэрчний эвлэлийн хороо нь жилд 2 удаа гишүүддээ дархлаа дэмжих бүтээгдэхүүн олгоно.	Аж ахуй эрхэлсэн Дэд захирал, СЭЗХ-ийн дарга	
66.	9.1	Ажилтны төлөөлөл нь ажилтнуудын ажлын байрны нөхцлийг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг тогтвортой байлгах, цалин хөлсийг үе шаттай нэмэгдүүлэх, ХАБЭА, нийгмийн асуудлыг сайжруулахад гол анхаарлаа чиглүүлнэ.	ҮЭХорооны дарга	

67.	9.2	Үйлдвэрчний эвлэлийн эрхийн тухай хуульд заасан эрх, баталгааг хангахын зэрэгцээ компани нь: 9.2.1. Үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн татварыг бэлэн бусаар хурааж Үйлдвэрчний эвлэлийн хорооны дансанд шилжүүлж байна. 9.2.2 Үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаа нь ажлын бус цагаар явагдах боловч шаардлагатай үед дараах ажиллагааг ажлын цагт явуулж болно. 9.2.3 Хамтын гэрээг боловсруулах, хэлэлцэх, батлах явц, үр дүнг хэлэлцэх 9.2.4 Хамтын гэрээнд тусгагдсан сургалт, зөвлөгөөн хийх	СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч Хуулийн мэргэжилтэн	
68.	9.3	Ажил олгогч нь Үйлдвэрчний эвлэлийн орон тооны сонгуульт ажилтанд Хамтын гэрээнд тусгагдсан дараах хөнгөлөлт, урамшуулалыг олгоно. Үүнд: 9.3.1. Сар, жилийн үр дүнгийн урамшуулал 9.3.2. Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл 9.3.3 Удаан жилийн нэмэгдлийг Эрчим хүчний салбарт 5-аас доошгүй жил ажилласан бол ажилласан жилээр тооцон олгоно.	СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч ХНМ	
69.	10.1	Гэрээний биелэлтийн явцыг жилд 2 удаа талууд төлөөлөгчдийн хамтарсан хурлаар хэлэлцэж холбогдох арга хэмжээг авч ажиллана.	Хуулийн мэргэжилтэн	
70.	10.2	Гэрээгээр хүлээсэн үүрэг зөрчигдсөн тохиолдолд аль нэг тал маргаантай асуудлыг шийдвэрлэхийн тулд төлөөлөгчдийн хуралдааныг 7 хоногийн дотор зарлан хуралдуулах эрхтэй бөгөөд нөгөө талдаа албан бичгээр мэдэгдэнэ.	Хуулийн мэргэжилтэн	
71.	10.3	Гэрээнд оролцогч талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт өөрчлөлт оруулж болно.	Хуулийн мэргэжилтэн	

72.	10.4	Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцад талуудын үйл ажиллагаанд саад учруулсан этгээдэд хариуцлага хүлээлгэх асуудлыг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.	Хуулийн мэргэжилтэн	
73.	10.5	Хамтын гэрээ нь талууд гарын үсэг зурж, эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн дараагийн гэрээ байгуулах хүртэлх хугацаанд хүчинтэй.	Хуулийн мэргэжилтэн	
74.	10.6	Удирдлагын бүтэц бүрэлдэхүүн, өмчлөлийн харьяалалд өөрчлөлт орох нь энэхүү хамтын гэрээ цуцлах үндэслэл болохгүй.	Хуулийн мэргэжилтэн	

ХЯНАСАН: ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Б.ГАН-ОЧИР

ТӨЛӨВЛӨСӨН:ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН Г.САРУУЛ